

"АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХЭРЭГЖИЛТ

**НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА
(2017 оны жилийн эцсийн байдлаар)**

2017.12.10

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хавсралт "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"	Хөтөлбөрийн зорилго: Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>АТГазар, НЗДТГ, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагууд</p> <p>I үе шат 2016-2019 он</p> <p>II үе шат 2020-2023 он</p> <p>Авлигатай тэмцэх газар, Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллагууд</p>
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p>Зорилт 2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 3. төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 4. худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 5. шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p>Зорилт 6. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;</p> <p>Зорилт 7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p> <p>Зорилт 8. иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах,</p>

		<p>хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 9. улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;</p> <p>Зорилт 10. шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 11. авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.</p>		
5.	Зардал			
		Төсөв 2015 он	Төсөв 2016 он	Төсөв 2017 он
		-	-	-
	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт		
6.	<p>1-р зорилтын хүрээнд:</p> <p>4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх;</p> <p>4.1.1.6.нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх;</p> <p>4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод</p>	<p>2016 онд 2, 2017 онд 1 албан хаагчийг нэр дэвшүүлж томилон, төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн байна.</p> <p>Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, дүгнэлгүйгээр албан тушаалд томилсон тохиолдолд байхгүй бөгөөд 2016 онд 8 албан хаагчийн, 2017 онд 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж томилсон. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг/ХАСУМ/-ийг АТГ-ын цахим системд бүртгэж байна. Мөн төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор гаргаж, Нийслэл дэх ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлж хэвшсэн.</p> <p>2017 онд байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог дахин шинэчлэн байгуулсан.</p>		

<p>хяналтын тогтолцоог бүрдүүлэх; 4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах;</p>	
<p>2-р зорилтын хүрээнд: 4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх; 4.1.2.5.төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах; 4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх; 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.</p>	<p>Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд байгууллагын танилцуулга, шинэчилсэн дүрэм, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, утасны дугаар, цахим хаяг, албан хаагчдын мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2016 оны үйл ажиллагааны 12 төрлийн тайлан, байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын төлөвлөгөө, цаг үеийн мэдээ мэдээллүүд, дотоод аудитын талаарх ойлголт, гарын авлага, стандарт, заавар, загвар, үйл ажиллагаандаа мөрддөг хууль тогтоомж, ёс зүйн дүрмүүд, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай болон бусад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд нь цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Мөн шилэн дансны тухай хуулийн дагуу аудит, хяналт шалгалтын багт ажилласан албан хаагчдын “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулсан. Дээрх мэдээллүүдийг өөрчлөгдсөн тухай бүр шинэчлэн оруулж байна.</p>
<p>3-р зорилтын хүрээнд: 4.1.3.1.улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх; 4.1.3.4.төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах; 4.1.3.6.нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох; 4.1.3.7.аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах; 4.1.3.8.аудитын үйл ажиллагааг хараат бус, хуулийн дагуу гүйцэтгэх</p>	<p>НДАА-ны аудитын баг Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн аудитыг гүйцэтгэхдээ http://shilendans.gov.mn/ цахим хуудсанд харъяа байгууллагуудын байршуулсан мэдээллийг аудитын дуусгавар хугацаа болох 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар баримтжуулсан ба цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн болон бусад холбогдох баримтуудтай харьцуулан тулгаж бүрэн, үнэн зөв эсэхийг магадласан. Энэхүү үзлэг шалгалтаар тус хууль болон журмыг хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлж байгаа нийт 4 байгууллагад албан шаардлага хүргүүлээ.</p> <p>Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх 2017 оны нэгдсэн шалгалтаар илэрсэн дээрх алдаа зөрчлүүдийн дийлэнх хувь нь тухайн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж, холбогдох ажилтан, албан хаагчид шинэчлэгдсэнтэй холбоотойгоор гарсан нь аудитын явцад ажиглагдсан. Аудитын баг байгууллагуудад ажиллах явцад тухай бүр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулсан ба</p>

<p>нөхцөл боломжийг бүрдүүлэх, шаардлагатай зарим тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах эрх зүйн орчинг бий болгох;</p>	<p>цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан. Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.04.18-ны өдрийн хуралдаанаар Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын буруутай шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг тухайн байгууллагаар төлүүлэхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлж, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу буруутай этгээдээр буцаан төлүүлэх асуудалд хяналт тавьж ажилласнаар хохирлыг бүрэн барагдуулсан. НДАА нь Нийслэлийн Дотоод аудитын хорооны даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2017 оны 3-р улирлын байдлаар 27 аудит, санхүүгийн хяналт шалгалт, 2 сэдвийн аудит, нийт 29 аудит, хяналт шалгалт хийж, 148,153,763.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэнээс 17,765,131.3 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 8,049,190.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 1,851,735.9 мянган төгрөгийн зөрчлийг залруулах, 120,487,705.7 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан. Дээрх 29 аудит, хяналт шалгалтаар улсын байцаагчийн 17 акт, 8 албан шаардлага, 137 зөвлөмж өгсөн.</p>
<p>5-р зорилтын хүрээнд: 4.1.5.14.хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх;</p>	<p>АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 12 албан хаагчийн 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь хүлээн авч, тайлан мэдээг гаргаж өгсөн. 2017 онд 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж томилсон. Оны эхний 11 сарын байдлаар аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 96 мэдэгдэл хүлээн авч, АТГ-ын програмд бүртгэсэн.</p>
<p>10-р зорилтын хүрээнд: 4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх; 4.1.10.5.авлигын эсрэг сайн туршлагыг олон нийтэд түгээх.</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, “Нийслэлийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, авлигын эсрэг сургалтын материалуудыг байгууллагын цахим хуудсаар болон албан хаагчдын цахим хаягаар танилцуулж сурталчилсан бөгөөд авлигын эсрэг зурагт хуудсуудыг байгууллагын самбар дээр байнга байршуулсан. АТГ-аас зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны сургалт”-д байгууллагын ЭБАТ хамрагдсан бөгөөд АТГ-г хүсэлт гаргаснаар 2017.11.29-нд байгууллагын 17 албан хаагчийг Авлигын эсрэг хууль тогтоомж, төрийн албан хаагчдын ёс зүйн талаар сургалтад хамруулсан.</p>

7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж, төрөл бүрийн ажил зохион байгуулахаар төлөвлөдөг ч төлөвлөгөөнд тусгасан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсөв хөрөнгө батлагддаггүй.												
8.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6	Зорилт 7	Зорилт 8	Зорилт 9	Зорилт 10	Зорилт 11
9.	Төсөл, хэрэгжилтийн үнэлгээ	хөтөлбөрийн нэгдсэн												

ХЯНАСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ